3.0 Нийтлэг асуултууд

Нийтлэг асуултууд

1. Судлагдахууны дүн гэж юу вэ?

Судлагдахууны дүн гэдэг нь сургалтын төлөвлөгөөний хичээл бүрийн харьяалагдах судлагдахуунаар бүлэглэж, тогтоосон дүрмийн дагуу бодож гаргасан дүн юм. Энэ дүнг суралцагчийн суралцаж байгаа хөтөлбөрийн төгсөх буюу 9, 12-р ангиудад гаргадаг.

Анхаарах зүйлс: Боловсролын түвшингийн төгсөх ангиуд буюу 9, 12-р ангиудын судлагдахууны дүнд тухайн боловсролын түвшингийн бүх ангиудын дүн бодогдохыг анхаарна уу.

2. Судлагдахууны дүнг хэрхэн засварлаж болох вэ?

Батлагдсан **судлагдахууны дүнг** сургалтын менежерийн эрхээр цуцлах үйлдэл хийгдсэний дараа засах боломжтой.

Сургалтын менежер хичээлийн дүн цонхоор **хичээл** эсвэл **суралцагчийн нэр** мэдээлэл дээр дарж орж суралцагч, хичээлийг нь сонгож **Дүн цуцлах** товч дарсанаар уг хичээлийн дүнг засварлах боломжтой байна.

3. Судлагдахууны дүн бодох тохиргоо

Судлагдахууны дүнг системээс бодож харуулах бөгөөд судлагдахууны дүн бодох тохиргоо болон тодруулах зүйлс байвал БСМС-ийн info@edu.mn болон **75778080** утсаар холбогдоно уу.

3.1 Судлагдахууны дүн бодуулах ажиллагаа

Суралцагч бүрийн судалсан хичээлийг судлагдахуун бүрээр бүлэглэж, тогтоосон дүрмийн дагуу судлагдахууны дүнг системээс бодож гаргах бүртгэлийн хэсэг юм. Энэ хэсэгт судлагдахуун бүрээр суралцагчийн дүнг бодуулна.

- Судлагдахууны дүнг бодуулахаас өмнө дараах мэдээллийг шалгах

1. Анги бүлгийн бүх суралцагчийн төлөв **Идэвхтэй**, баталгаажуулалтын төлөв **Батлагдсан** байх. Өөрөөр хэлбэл бүлгийн бүх суралцагч судлагдахууны дүн бодох жагсаалтад орж ирсэн эсэх.
2. Судлагдахууны дүн бодох хэсэгт тухайн ангид судалсан байх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан судлагдахуун бүрэн эсэхийг шалгах

- Заавал хичээл
- Сонгон хичээл
- Төрөлжсөн болон гүнзгийрүүлэн судалсан хичээл

3. Хичээл бүрийн 7 хоногт судлах цаг зөв эсэх (Батлагдсан сургалтын төлөвлөгөө, 7 хоногт судлах цагийг системээс бодож харуулна. Үүнийг хичээлийн дүн оруулахдаа харна.)

- Заавал судлах хичээлийн хувьд засах боломжгүйгээр харуулна.
- Сонгон, төрөлжсөн болон гүнзгийрүүлэн үзсэн хичээлийн хувьд засах боломжтой байна.

4. Заавал, сонгон, төрөлжсөн болон гүнзгийрүүлэн судалсан суралцагчийн хичээлийн дүнг бүлгийн суралцагч бүрээр үнэн зөв оруулж баталгаажуулсан эсэх

- Сонгон, төрөлжсөн, гүнзгийрүүлэн судалсан хичээл мөн эсэхийг нягтлах (хичээлийн дүн оруулах хэсэгт хянах. Хянахдаа дүн, үнэлгээ оруулж байгаа хичээлийн индексийн сүүлийн орон:

- 1 бол Заавал судлах
- 2 бол Сонгон судлах
- 3 бол Гүнзгий хичээл
- 4 бол Төрө

3.2 Бүртгэлийн маягт

Суурь болон бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөгчдийн боловсролын баримт бичиг дээр тавигдах хичээлийн дүн, үнэлгээ (заавал, сонгон, мэргэжлийн /гүнзгийрүүлэн судалсан хичээл болон улсын шалгалт) болон сурлагын үнэлгээний дундаж, боловсролын баримт бичгийн дугаар зэрэг мэдээллийг харуулна.

Суралцагчийн дараах мэдээллийг шалгана.

- Хичээлийн дүн, үнэлгээ болон 7хоногт судалсан цаг
- Заавал судалсан хичээл (Тухайн түвшний болон өмнөх анги)
- Сонгон судалсан хичээл (зөвхөн судалсан хичээл)
- Мэргэжлийн /гүнзгийрүүлэн судалсан хичээл (зөвхөн судалсан хичээл)
- Улсын шалгалтын дүн
- Суралцагчийн хувийн мэдээлэл
- Овог
- Нэр
- Регистр
- Сурлагын үнэлгээний дундаж хувь
- Боловсролын баримт бичгийн дугаар (Суурь боловсролын гэрчилгээ, бүрэн дунд боловсролын үнэмлэх)

Дараалал:

1. Суралцагчийн судалсан хичээлийн дүн /үнэлгээ/, 7 хоногт судалсан цаг
- Заавал, сонгон болон мэргэжлийн /гүнзгийрүүлэн судалсан хичээл (Суурь боловсрол бол 6-9 ангийн, бүрэн дунд боловсрол бол 10-12 ангид сургалтын төлөвлөгөөгөөрх судлах хичээл)
    - Дүн, үнэлгээ өмнө оруулсан бол системээс харуулна. Байхгүй бол нөхөж оруулна
    - &lt

3.3 Тушаал журам

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ

БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВИЙН

ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 07 өдөр Дугаар А/46 Улаанбаатар хот

Суралцагчийн сурлагын үнэлгээний дундаж
хувь бодох аргачлал батлах тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/156 дугаар тушаалаар батлагдсан "Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд боловсролын баримт бичиг олгох, дүйцүүлэх журам"-ын 4 дүгээр хэсгийн 4.6.5 дахь заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Боловсролын үнэлгээний төвийн дүрэм"-ийн 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Суралцагчийн сурлагын үнэлгээний дундаж хувь бодох аргачлал"-ыг хавсралтаар батлсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын хэлтсийн дарга /Ш.Шижир-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ГАН-ЭРДЭНЭ

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2018 оны 07 сарын 25-ны өдрийн 5967 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 29 өдөр Дугаар А/425 Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3 дахь хэсэг, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар бүлгийн 3.2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам"-ыг хавсралтаар батлалсугай.

2. "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам"-ыг 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн өмчийн бүх хэлбэрийн бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагад мөрдсүгэй.

3. Энэхүү журмыг албан бус сургалтын дүйцсэн хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчдыг үнэлэхэд баримталсугай.

4. Энэхүү тушаалаар батлагдсан журмын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-Очир/, Боловсролын үнэлгээний төв /Ж.Ган-Эрдэнэ/, нийслэлийн Боловсролын газар, аймгуудын Боловсрол, соёл, урлагийн газарт тус тус даалгасугай.

5. Журмыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг жил бүр улсын төсөвт тусгаж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Х.Галсанхүү/, Боловсролын үнэлгээний төв /Ж.Ган-Эрдэнэ/-д тус тус үүрэг болгосугай.

6. Журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2013 оны "Журам, загвар шинэчлэн батлах тухай" А/309 дүгээр тушаалаар батлагдсан "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон чанарын үнэлгээний журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Ц.ЦОГЗОЛМАА

0001553